



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

“Эф Си Икс” ХХК-ийн
тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 30.1.1, 63.1.5, Хорооны 2013 оны 506 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 11.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эф Си Икс” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсонтой холбогдуулан улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд холбогдох өөрчлөлт оруулахыг “Эф Си Икс” ХХК /Н.Сарангэрэл/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харъяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор тус тус мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

600260